



ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 71

Хэрлэн сум

Биеийн тамир, спортын газрын
Тогтоол шийдвэр, тайлан мэдээ, хүний нөөц
хариуцсан ахлах мэргэжилтний сул орон тоонд
томилуулахаар нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны тусгай шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо (70,75) авсан Алтанхуягийн Алтантуяаг Биеийн тамир, спортын газрын Тогтоол шийдвэр, тайлан мэдээ, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2.Нэр дэвшигч А.Алтантуяаг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Биеийн тамир, спортын газрын дарга (Г.Нэргүйбаатар)-д зөвлөсүгэй.

3.Энэхүү тогтоолыг Биеийн тамир, спортын газарт хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА